Бараа материалын оны эхний үлдэгдэл 299,015.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 276,751.2 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС-ийн 181,940.3 мянган төгрөг, Цэцэрлэгийн 81,21.6 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвийн 126,082.1 мянган төгрөг, Соёлын төвийн 11,388.1 мянган төгрөг, нийт 401,332.1 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг улсын төсвийн байгууллагад шилжүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт

ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар:

- Шатахууны талоны 600.0 мянган төгрөгийн үлдэгдлийг бараа материалын тооллогын бүртгэлд хөтлөөгүй нь тухайн хөрөнгө оршин буй эсэхийг нотлох боломжгүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- Бараа материалын дансанд 2021 онд бэлтгэсэн 9,000.0 мянган төгрөгийн үнэтэй 279 шуудай хорголжин тэжээлийг борлуулаагүй үр ашиггүй хөрөнгө бэлтгэсэн, орон нутагт зах зээлд борлогдож байгаа үнэ нь дансны үнээс доогуур тул борлогдоогүй үлдэгдэлтэй зөрчилд албан шаардлага бичигдсэн.
- Санхүүгийн үр дүнгийн тайлан дахь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого нь үндсэн хөрөнгийн болон бараа материалын тайлангийн тодруулгаас 12,500.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байсныг аудитын явцад залруулга хийгдсэн.

Засаг даргын нэгтгэсэн санхүү байдлын тайланд бараа материалын үлдэгдэлд ЕБС-ийн 45,458.3 мянган төгрөгийн шатах тослох материалыг орлогоор бүртгэж, үлдэгдлээр тайлагнасан байсныг аудитын явцад залруулсан.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,120,718.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,694,867.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	7,394,985.73	1,468,322.77	-5,926,662.95
Барилга, байгууламж, орон сууц	6,825,513.71	877,442.70	-5,948,071.01
Авто-тээврийн хэрэгсэл	67,178.54	174,693.48	107,514.94
Машин тоног төхөөрөмж(компьютер)	230,058.00	147,918.78	-82,139.22
Тавилга, аж ахуйн эд хогшил	120,379.81	20,815.19	-99,564.62
Зам, гүүрийн байгууламж	11,063.38	8,960.78	-2,102.60
Бусад үндсэн хөрөнгө	121,955.20	237,448.45	115,493.25
Номын фонд	18,837.08	1,043.40	-17,793.68
Биет бус хөрөнгө	420,600.71	652,396.06	231,795.35
Программ хангамж	954.31	448.06	-506.25
Бусад биет бус хөрөнгө	419,646.40	651,948.00	232,301.60

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн 2,120,718.8 мянган төгрөгийн үлдэгдлийн 94,3 хувь буюу 1,998,825.2 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 5,7 хувь буюу 121,696.7 мянган төгрөгийг Ойн анги, 196.9 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 5,694,867.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 1,003,983.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагууд ЕБС-ийн 5,299,361.7 мянган төгрөгийн, Цэцэрлэгийн 575,776.2 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн төвийн 371,867.2 мянган төгрөгийн, Соёлын төвийн 226,861.9 мянган төгрөгийн, нийт 6,473,867.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

ЗДТГ-ын санхүүгийн тайлангийн аудитаар шинэ хөдөө төслийн хүрээнд нийлүүлэгдсэн 105,872.7 мянган төгрөгийн хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгийн авто тээврийн хэрэгсэл дансанд буруу ангилан бүртгэж тайлагнасныг аудитын явцад залруулсан.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 3,312.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,283.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон өглөг	0.0	0.0	
Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,442.00		-1,442.0
Байгууллагад төлөх өглөг	586.3	3,312.2	2,725.9
Дүн	2,028.3	3,312.2	1,283.9

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 1,283.9 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөгжлийн санд 2,899.0 мянган төгрөгийн өглөгийг шинээр бүртгэсэнтэй холбоотой байна.

Өр төлбөрийн жилийн эцсийн 3,312.2 мянган төгрөгийн үлдэгдлийн 2,899.0 мянган төгрөг нь орон нутгийн хөгжлийн сангийн, 346,9 мянган төгрөг нь эмийн эргэлтийн сангийн, 66.3 мянган төгрөг нь ойн ангийн өглөг эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

Засаг даргын аудитад ирүүлсэн нэгтгэсэн санхүү байдлын тайланд ЕБС-ийн халаалтын өглөг 45,458.3 мянган төгрөгийг буруу нэгтгэснийг аудитын явцад залруулсан.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3,886,168.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,555,283.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр /			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,432,225.7	1,112,351.8	-2,319,873.90
Хуримтлагдсан үр дүн	6,009,226.3	2,773,817.1	-3,235,409.20
Өмнөх үеийн үр дүн	3,248,036.4	7,921,559.8	4,673,523.40
Тайлант үеийн үр дүн	15,210.4	-5,374,650.1	-5,389,860.50
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,745,979.5	226,907.4	-2,519,072.10
Дүн	9,441,452.0	3,886,168.9	-5,555,283.10

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 5,555,283.1 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагуудын хөрөнгийг шилжүүлснээр засгийн газрын сан 2,319,873.9 мянган төгрөгөөр, хөрөнгийн дахин үнэлгээ 2,519,072.1 мянган төгрөгөөр буурч, өмнөх үеийн үр дүн 4,673,523.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант үеийн үр дүн 5,389,860.5 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Батсүмбэр сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын 2022 оны төсвийн төсөлд хүргүүлсэн орлого, зардлыг тооцоолол, төлөвлөгөөг ирүүлээгүй болно.

Батсүмбэр сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн “сумын 2022 оны төсөв батлах тухай” 02 дугаар тогтоолоор 2022 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 866,364.8 мянган төгрөгөөр, төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 2,433,421.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Батсүмбэр сумын ИТХ-ын 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн “Сумын 2022 оны тодотгосон төсөв батлах тухай” 02 дугаар тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 10,671.0 мянган төгрөгөөр бууруулан 855,693.8 мянган төгрөгөөр, 2022 оны төсвийн жилд зарцуулах зарлагын хэмжээг 1,969,664.0 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 150,300.0 мянган төгрөгөөр, нийт 2,119,964.0 мянган төгрөгийг тодотгон баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 855,693.8 мянган төгрөг, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс 651,205.5 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 316,623.0 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдлээс 110,000.0 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 6,642.5 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 150,300 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг 651,205.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 1,364,280.2 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 110,056.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 92,403.0 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлж төсвийн тохируулга хийгдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,617,776.5 мянган төгрөг буюу 76,3 хувьтай байгаа нь цалин хөлс, НДШ-ийн зардал 34,595.8 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардал 6,133.1 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 328.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 668.8 мянган төгрөг, дотоод томилолтын зардал 12.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 257.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 42,037.7 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 502.9 мянган төгрөг, хөрөнгийн зардал 300,744.7 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалсан байна.

Цалин шимтгэлийн зардал орон тоо дутуу ажилласнаас, хөрөнгийн зардал тендер сонгон шалгаруулалттай холбоотойгоор хэмнэгдсэн байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага-үндсэн үйл ажиллагааны зардал	73,515.5	70,342.9	3,172.6	95.7
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-үндсэн үйл ажиллагааны зардал	602,119.7	477,338.1	124,781.6	79.3
3	Ерөнхий боловсролын сургууль-тогтмол зардал	479,358.6	479,358.6	0.0	100.0
4	Сургуулийн өмнөх боловсрол-тогтмол зардал	108,341.5	106,608.9	1,732.6	98.4
5	Соёлын үйлчилгээ-тогтмол зардал	28,411.2	25,840.2	2,571.0	91.0
6	Эрүүл мэндийн төв-тогтмол зардал	55,257.2	54,630.8	626.4	98.9
7	Ойн анги- үндсэн үйл ажиллагааны зардал	66,146.6	57,787.5	8,359.1	87.4
8	Хоршоо хөгжүүлэх сан- үндсэн үйл ажиллагааны зардал	150,300.0	40,100.0	110,200.0	26.7
9	Орон нутгийн хөгжлийн сан-хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ	556,514.0	305,769.3	250,744.7	54.9
	Дүн	2,119,964.3	1,617,776.3	502,188.00	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газар нь 95,397.8 мянган төгрөг, ИТХ 400.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн төв эхний үлдэгдэл 12,526.7 мянган төгрөг нийт 108,324.6 мянган төгрөгийг зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 9 хөтөлбөрийн 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2022.01.01-2022.12.31	Сумын ИТХТ, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, Жилд 4-өөс	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил	73,515.5	70,342.9

			доошгүй удаа хурал хийнэ.	үйлчилгээгээр хангаж ажилласан 95.7 %		
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01-2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хэрэгжүүлэх	Хэрэгжилт 79,3%	602,119.7	477,338.1
3	70106-Хоршоо хөгжүүлэх сан	2022.01.01-2022.12.31	Хоршоо хөгжүүлэх сангийн журмыг дагаж мөрдөх	Шаардлага хангасан зээл ирээгүй тул олголт багассан 26,7%	150,300.0	40,100.0
4	71802-Ерөнхий боловсролын сургууль	2022.01.01-2022.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	Хэрэгжилт 100%	479,358.6	479,358.6
5	71801-Сургуулийн өмнөх боловсрол	2022.01.01-2022.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	Хэрэгжилт 98,4%	108,341.5	106,608.9
6	71702-Соёлын үйлчилгээ	2022.01.01-2022.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	Хэрэгжилт 91,0%	28,411.2	25,840.2
7	71602-Эрүүл мэндийн төв	2022.01.01-2022.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	Хэрэгжилт 98,9%	55,257.2	54,630.8
8	71403-Ойн анги	2022.01.01-2022.12.31	Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх	Хэрэгжилт 87,4%	66,146.6	57,787.5
9	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2022.01.01-2022.12.31	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх	Хэрэгжилт 54,9%	556,514.0	305,769.3

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын орлого бүрдүүлэлт, шилэн дансны мэдээллийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2023 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 05/62 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2022 оны төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2022 оны төсвийг, суурь үзүүлэлтийг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 2022 оны урсгал үйл ажиллагааны зардал 1,969,664.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 29,544.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 22,158.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг дарга нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл ирүүлээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудсанд өөрчлөгдсөн ерөнхий нягтлан бодогчийн нэрийг солиогүй, тайлант онд байршуулбал зохих

мэдээллээс 28 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг байршуулаагүй төлөвтэй байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий Эмийн эргэлтийн сангийн 30,018.8 мянган төгрөгийн 5 орлогын гүйлгээ, 41,300.0 сая төгрөгийн 4 зарлагын гүйлгээ, Хоршоо хөгжүүлэх сангийн орлогын 7 гүйлгээ, зарлагын 1 гүйлгээг мэдээлээгүй ба хоршоо хөгжүүлэх сангийн 94,128.2 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулахтай холбоотой 2 тушаал болон Орон нутгийн хөгжлийн сангийн 4 ажилтай холбоотой 253,923.0 мянган төгрөгийн шийдвэр, гэрээг мэдээлээгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмжийг хэрэгжүүлэн, сумын Засаг даргын 2022 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 05/152 дугаартай албан бичгээр хэрэгжилтийг ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,382.3	1	1,382.3	
Албан шаардлага	3	305,189.5	3	305,189.5	
Зөвлөмж	4	131,199.9	4	131,199.9	100
Нийт дүн	3	437,771.7	3	437,771.7	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 1,464,179.7 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 1,464,179.7 мянган төгрөгийн алдааг залруулав.

1. Засаг даргын нэгтгэсэн санхүү байдлын тайланд Төрийн сангийн харилцах дансны эцсийн үлдэгдлийг 1,225,925.1 мянган төгрөгөөр тайлагнасан нь Сангийн яамны И-хуулганаас татсан 1,300,674.1 мянган төгрөгөөс 74,749.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

2. Нэгтгэсэн санхүү байдлын тайланд өр төлбөр дансанд ЕБС-ийн халаалтын өглөг 45,458.3 мянган төгрөгийг буруу нэгтгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "ангилал", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

3. Нэгтгэсэн санхүүгийн тайланд ЕБС-ийн 45,458.3 мянган төгрөгийг бараа материалын дансанд шатах тослох материалыг орлогоор бүртгэж, үлдэгдэлд тайлагнасан байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "ангилал", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

4. Засаг даргын нэгтгэсэн санхүү үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй гарсан зардал үндсэн хөрөнгө дансанд ЕБС-ийн 1,047,737.3 мянган төгрөг, Соёлын төвийн 226,861.9 мянган төгрөгийг, бараа материал дансанд Соёлын төвийн 11,388.2 мянган төгрөгийг шилжүүлсэн бичилт зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "ангилал", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

5.Нэмэлт санхүүжилтийн тайланд эрүүл мэндийн төвийн 12,526.7 мянган төгрөгийг мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэйгээр тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "ангилал", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 419,370.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 419,370.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 159,6 хувиар давж биелсэн боловч 6 нэр төрлийн орлого 18,2-67,7 хувиар тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр жигд биелүүлэх

2. Орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орлогын гүйцэтгэлийн тодруулга тайланд төсвийн орлогын төлөвлөгөөг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тодотгон батлагдсан дүнгээс 10,671.0 мянган төгрөгөөр,

гүйцэтгэлийг аймгийн Татварын хэлтсийн аудитад ирүүлсэн 2022 оны төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлээс 4,418.5 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан төлөвлөгөөнд өөрчлөлт орсон тохиолдолд аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст мэдэгдэн өөрчлөлтийг оруулж байх ба татварын байцаагчтай орлогын дүнг сар улирлаар тохирч байх

3. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд өөрчлөгдсөн ерөнхий нягтлан бодогчийн нэрийг солиогүй, тайлант онд байршуулбал зохих мэдээллээс 28 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг байршуулаагүй төлөвтэй байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий Эмийн эргэлтийн сангийн 30,018.8 мянган төгрөгийн 5 орлогын гүйлгээ, 41,300.0 сая төгрөгийн 4 зарлагын гүйлгээ, Хоршоо хөгжүүлэх сангийн орлогын 7 гүйлгээ, зарлагын 1 гүйлгээг мэдээлээгүй ба хоршоо хөгжүүлэх сангийн 94,128.2 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулахтай холбоотой 2 тушаал болон Орон нутгийн хөгжлийн сангийн 4 ажилтай холбоотой 253,923.0 мянган төгрөгийн шийдвэр, гэрээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" гэж заасантай бүрэн нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн мэдээлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	5	1,464,179.7			5	1,464,179.7	5	1,464,179.7				
ЗДТГ	2	121,672.1			2	121,672.1	2	121,672.1				
ИТХ	1	154,000.0			1	154,000.0	1	154,000.0				
Дүн	8	1,739,851.8			8	1,739,851.8	8	1,739,851.8				

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг дарга	2	15,089.5					2	15,089.5				
ЗДТГ	3	9,600.0	1	600.0	1	9,000.0	1					
Ойн анги	2	563.2					2	563.2				
Дүн	7	25,252.7	1	600.0	1	9,000.0	5	15,652.7				

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Засаг дарга	1	0					1	
ОНХС	1	253,923.0					1	253,923.0
ХХС	1	94,128.2					1	94,128.2
ЭЭС	1	71,318.8					1	71,318.8
Ойн анги	1						1	0
Дүн	5	419,370.0					5	419,370.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	5	419,370.0					5	419,370.0